



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1/29

Улаанбаатар хот


Гэрээр тусгаарлагдсан иргэдэд тусламж, үйлчилгээний бүрэлдэхүүн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэг, Коронавируст халдварын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай ЭМС-ын 2021 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дүгээр тушаал, "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай" ЭМС-ын 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/140 дүгээр тушаал, НЭМГ-ын даргын 2021 оны А/21 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэрийн тусгаарлалтад шилжсэн иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх эмч нарыг нэгдүгээр, төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эмч нарын багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношлогоо, эмчилгээний түр заавар болон Коронавируст халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдолд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэхэд баримтлан ажиллах халдвар хамгааллын дэглэмийн түр зааварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Гэрээр тусгаарлагдаж байгаа иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, үзлэг зөвлөгөөг нэгдүгээр хавсралт дахь Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар үзүүлэхийг үүрэг болгосугай.
3. Өрхийн эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэдэд утсаар зөвлөгөө өгөх, шаардлагатай тусламж үйлчилгээг гэрээр үзүүлж ажиллахыг төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмч нарын багт үүрэг болгосугай.
4. Багийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр ханган ажиллахыг Өрхийн эрүүл мэндийн дарга нар болон Эрүүл мэндийн төвийн амбулаторийн эрхлэгч /Г.Цолмон, Г.Оюунцэцэг/ нарт даалгасугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/-д үүрэг болгосугай.


ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ



30170 702021

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн
029 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ГЭРИЙН ТУСГААРЛАЛТАД ШИЛЖСЭН ИРГЭДЭД АНХАН ШАТНЫ
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭМЧ НАР

№	Тусламж үйлчилгээ	Эмчийн овог нэр	Албан тушаал	Утас
1	1-р хороо Мөнхбадрах-Өрх	Д.Адьяасүрэн	Их эмч	90944747
2		Б.Жайнагуль	Их эмч	88526770
3	2-р хороо Тэрмэстий	Э.Гэрэлчимэг	Их эмч	88063198
4		А.Мянганзул	Их эмч	88863032
5	3-р хороо Энхтитэм	Д.Марал	Их эмч	88820555
6		А.Баярлах	Их эмч	99046799
7	4-р хороо Цэц-До	А.Долгорсүрэн	Их эмч	91213344
8		Б.Саруул	Их эмч	80064774
9	5-р хороо Манал-Үйлс	Б.Сарантуяа	Их эмч	99005069
10		Ц.Норовсүрэн	Их эмч	99008464
11	6-р хороо Чанд-Авиа	С.Жавзан	Их эмч	88170773
12		Б.Надмидцэрэн	Их эмч	94322137
13	7-р хороо Хашчагнуур	Г.Цэен	Их эмч	95955930
14		Д.Сэргэлэн	Их эмч	99175066
15	8-р хороо Уясах	Ц.Ганчимэг	Их эмч	88028416
16		Г.Уртнасан	Их эмч	99469251
17	9-р хороо Аяут	З.Эрхэмтөгс	Их эмч	90095399
18		Б.Болормаа	Их эмч	99735396
19	10-р хороо Аминтус	Т.Чандмань-Эрдэнэ	Их эмч	96996989
20	11-р хороо Амгалан-Өрх	С.Одончимэг	Их эмч	88732865
21	12-р хороо Био-Асралт	Д.Нарантуяа	Их эмч	99131560
22		Э.Батчимэг	Их эмч	88077585
23	13-р хороо Туул тосгон ЭМТ	Г.Мягмарсүрэн	Их эмч	91211535
24		М.Дайриймаа	Их эмч	91922993
25	14-р хороо Энх-Амгалан Өлзийт	Э.Батцэцэг	Их эмч	95115448
26		Н.Мөнх-Ундрах	Их эмч	86128773
27	15-р хороо Мэндсаруул-Өрх	Ч.Амарзаяа	Их эмч	99155266
28	16-р хороо Энхбуянт манал	Т.Нансалмаа	Их эмч	99281356
29		М.Орхонбаяр	Их эмч	99127589
30	17-р хороо Амгалан-Өрх	С.Мөнхжаргал	Их эмч	99958765
31	18-р хороо Мэндсаруул-Өрх	Г.Оюунгэрэл	Их эмч	99150419
32	19-р хороо Мэндсаруул-Өрх	Б.Отгонзаяа	Их эмч	99274917
33	20-р хороо Энхтитэм	Г.Дүүрэнбаяр	Их эмч	99296351
34	21-р хороо Аминтус	Б.Ариунзаяа	Их эмч	88610787

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн
12/29 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт


ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ НАРЫН
НЭГДҮГЭЭР БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Тусламж үйлчилгээ	Эмчийн овог нэр	Албан тушаал	Утас
1	Мэдрэлийн өвчний тусламж үйлчилгээ	Ц.Чулуун	Мэдрэлийн эмч	99891418
2	Хавдрын өвчний тусламж үйлчилгээ	С.Солонго	Хавдрын эмч	89060984
3	Зүрхний өвчний тусламж үйлчилгээ	Д.Эрдэнэтуяа	Зүрх судасны эмч	99472545
4	Сэтгэцийн өвчний тусламж үйлчилгээ	Л.Хоролсүрэн	Сэтгэцийн эмч	80050522
5	Хүүхдийн өвчний тусламж үйлчилгээ	Т.Энхээ	Хүүхдийн зохицуулагч эмч	99692494
6	Нүүр амны өвчний тусламж үйлчилгээ	Г.Төрбат	Шүдний эмч	99232330
7	Гэмтэл, мэс заслын өвчний тусламж үйлчилгээ	М.Болдбаатар	Гэмтлийн эмч	96020943
8	Эмэгтэйчүүдийн өвчний тусламж үйлчилгээ	Н.Дэлгэр	Эмэгтэйчүүдийн зохицуулагч эмч	99418124
9	Чих, хамар хоолойн өвчний тусламж үйлчилгээ	Н.Энхтуяа	Чих хамар хоолойн эмч	94066262
10	Дүрс оношилгоо	Б.Рагчаасүрэн	ЭХО-ны эмч	99247347
11	Рентген	Б.Эрдэнэчулуун	Рентгений эмч	96664567

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ НАРЫН
ХОЁРДУГААР БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Тусламж үйлчилгээ	Эмчийн овог нэр	Албан тушаал	Утас
1	Мэдрэлийн өвчний тусламж үйлчилгээ	З.Уранчимэг	Мэдрэлийн эмч	99079993
2	Хавдрын өвчний тусламж үйлчилгээ	Ж.Цэцэгмаа	Хавдрын эмч	94117015
3	Зүрхний өвчний тусламж үйлчилгээ	Д.Соёл-Эрдэнэ	Зүрх судасны эмч	99868627
4	Сэтгэцийн өвчний тусламж үйлчилгээ	Л.Хоролсүрэн	Сэтгэцийн эмч	80050522
5	Хүүхдийн өвчний тусламж үйлчилгээ	Н.Лхагвадулам	Хүүхдийн зохицуулагч эмч	99144919
6	Нүүр амны өвчний тусламж үйлчилгээ	Х.Болор-Эрдэнэ	Шүдний эмч	99954383
7	Гэмтэл, мэс заслын өвчний тусламж үйлчилгээ	Н.Габит	Гэмтлийн эмч	99969609
8	Эмэгтэйчүүдийн өвчний тусламж үйлчилгээ	С.Ариунжаргал	Эмэгтэйчүүдийн зохицуулагч эмч	99054521
9	Чих, хамар хоолойн өвчний тусламж үйлчилгээ	Д.Уранцэцэг	Чих хамар хоолойн эмч	99172622
10	Дүрс оношилгоо	Г.Оюунцэцэг	ЭХО-ны эмч	99070630
11	Рентген	Б.Эрдэнэчулуун	Рентгений эмч	96664567

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2021 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн
#299 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



Коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношлогоо, эмчилгээний түр заавар
(Эрүүл мэндийн сайдын 2021 оны 03 сарын 04-ны өдрийн А/101 дугаар тушаал,
03 сарын 18-ны өдрийн А/140 дугаар тушаал)

Эмнэлзүйн илрэл

Халуурах, ханиалгах, хоолой өвдөх, хамар битүүрэх, нус гоожих, толгой өвдөх, ядрах, үнэрлэх болон амтлах мэдрэхүй алдагдах зэрэг шинж тэмдгүүд илэрнэ.

Хүнд хэлбэрээр өвдөхөд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс:

- Хавдар
- Бөөрний архаг үрэвсэл
- Уушигны архаг бөглөрөлт өвчин
- Цуллаг эрхтэн шилжүүлэн суулгасны дараах дархлаа дарангуйлагдсан байдал
- Таргалалт (БЖИ $\geq 30\text{кг/м}^2$)
- Зүрх судасны хүнд өвчин (зүрхний дутагдал, титэм судасны өвчин, кардиомиопати)
- Тамхидалт
- Хадуур эст өвчин
- Чихрийн шижин хэв шинж II
- Жирэмсэн

Хүндрэлд нөлөөлж байгаа хавсарсан эмгэгүүд:

- Багтраа (хүнд, хүндэвтэр)
- Тархины судасны өвчин
- Уйлинхай фиброз (муковисцидоз)
- Артерийн даралт ихсэлт
- Дархлаа дарангуйлагдсан байдал
- Элэгний өвчин
- Мэдрэлийн эмгэг байдал
- Жингийн илүүдэл (БЖИ ≥ 25 боловч $< 30\text{кг/м}^2$)
- Уушигны фиброз
- Талассеми
- Чихрийн шижин I хэв шинж

Дараах эмгэгээр хүндэрч нас барахыг анхаарах:

- Бактерийн шалтгаант хатгаа
- Амьсгалын цочмог дистресс хам шинж
- Үжил
- Миокардын өвчин

- Зүрхний хэм алдалт
- Бөөрний цочмог гэмтэл
- Бүлэнт эмболизм
- Гастрит, ходоод дээд гэдэсний шархлаа
- Ишемийн энтерит

ЭМНЭЛЗҮЙН АНГИЛАЛ

Хүндийн зэрэг	Хүчилтөрөгчийн ханамж	Эмнэлзүйн байдал	Эмнэлзүйд анхаарах
Хөнгөн	$SpO_2 \geq 94\%$	Зөвхөн ханиалгаж байгаа, амьсгаадаагүй	- Ихэвчлэн вирусийн халдварын шинж аяндаа засрах боловч - Эрсдэлтэй бүлгийн иргэний хяналт, эмчилгээг эмнэлэгт хийнэ
Хүндэвтэр	$SpO_2 < 94\%$	Амьсгалын замын халдварын болон хатгааны эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн	- Эмнэлэгт анхааралтай хянаж эмчилгээг хийнэ. - Зарим тохиолдолд чимээгүй гипосеми илэрч, амьсгалын дутагдлын шинж илрэхгүй
Хүнд	$SpO_2 \leq 92\%$	Хүчилтөрөгчөөр дэмжих эмчилгээ хэрэгцээтэй болно	- Амьсгалын дутагдлын шалтгааныг тооцож үзэх хэрэгтэй. - Өвчтөнийг амьсгалын дутагдал эмчлэх бололцоотой эмнэлэгт эмчилнэ. - Инвазив бус амьсгал дэмжих эмчилгээ CPAP хийхээс зайлсхийж, аэрозоль үүсэхээс сэргийлнэ.
Нэн хүнд	Хүчилтөрөгчийн ханамж нь энгийн хүчилтөрөгч эмчилгээнд хангалтгүй, хүнд хэлбэрийн гипоксеми илэрнэ.	ЭЭТ-т эмчлэх эсвэл амьсгалыг зохиомлоор удирдах шаардлагатай	- Амьсгалыг зохиомлоор удирдах үед хийх хяналтын үзүүлэлтээс хамаарч уушгины хүнд хэлбэрийн хатгаа ангилагдах ба эмчилгээний аргачлал хамаарна. (L- хэлбэр ба H- хэлбэр) - L-хэлбэр: уушгины эд зөөлөн ба агаарын сэлгэцлийн хэмжээ нэмэгддэг. - H-хэлбэр: уушги хавагнадаг тул ЭКМО хийх асуудлыг шийдвэрлэнэ. - L-хэлбэрээс H- хэлбэрт орох процессийг үнэлэхэд бэрхшээлтэй.

Оношийн код

OUӨА-10 ангиллын дагуу коронавируст халдвар (КОВИД 19) оношийн кодыг бичнэ.

U07.1- Вирусологийн шинжилгээгээр батлагдсан тохиолдол

U07.2- Эмнэлзүй болон эпидемиологийн шалгуур үзүүлэлтээр коронавируст халдвар онош тавигдсан боловч лаборатори, вирусологийн шинжилгээ нь баталгаатай бус эсвэл хийгдэх боломжгүй тохиолдол

Z03.8- Коронавируст халдвар (КОВИД 19) сэжиглэн ажиглалтанд буй тохиолдол

Z22.8- Коронавируст халдвар тээгч

Z11.5- Коронавируст халдвар (КОВИД 19)-ыг илрүүлэх зорилгоор хийгдэж буй тандалт

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн явцыг харгалзан хэрэгжүүлэх **эмчилгээний зөвлөмж:**

ХӨНГӨН ТОХИОЛДОЛ:

- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хөнгөн тохиолдолд бусдад халдвар тархаахгүй байх, халдвар хамгааллын дэглэмийг сахих нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тусгаарлан хянана.
- Ихэнх хөнгөн тохиолдолд өвөрмөц эмчилгээ хийх заалтгүй аяндаа эдгэрдэг.
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдолд шингэн зүйл сайн уулгана, илчлэг сайтай хоол хүнсээр хангана.
- Шаардлагатай тохиолдолд халуун бууруулах, зовиур багасгах, өвдөлт намдаах гэх мэт шинж тэмдгийн эмчилгээ хийнэ.
- Хөнгөн зэргийн үед эмчлэх болон урьдчилан сэргийлэх зорилгоор вирусийн эсрэг бэлдмэл, антибиотик эмчилгээ хэрэглэхийг зөвлөхгүй.
- Хүчилтөрөгч эмчилгээ шаардлагагүй, нянгийн шалтгаант ринит, синусит, бронхиттай өвчтөнд амоксициллин, доксициклин, макролидын бүлгийн антибиотик **уухаар** хэрэглэж болно.
- Өвчтөний биеийн байдал, эмнэлзүйн шинж тэмдгийг тогтмол хянаж, дараахь шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт хэвтүүлнэ. Үүнд: 38°C-аас дээш халуурах, амьсгалын тоо 20-с дээш болох, зүрхний цохилтын тоо 100-аас дээш болох, SpO₂ <94% болох, цээж давчдах, амьсгаадах зэрэг шинж тэмдгийг анхаарах шаардлагатай.
- Үзлэг, шинжилгээгээр өвчтөнг хөнгөн гэж тодорхойлсон байсан ч өвчин эхэлснээс хойш 2 долоо хоногийн дотор өвчин хурдан даамжирч болзошгүй. **Өвчин даамжирч буйг гипоксемийн шинжүүд илтгэнэ.**
- Эрсдэлт хүчин зүйлтэй, тухайлбал чихрийн шижин, зүрхний дутагдал, амьсгалын архаг дутагдал, артерийн даралт ихсэлт, хорт хавдар, дархлаа дарангуйлагдсан байдал, жирэмсэн тохиолдолд онцгой хяналт шаардлагатай.

ХҮНДЭВТЭР ТОХИОЛДОЛ (Амьсгалын дутагдалгүй)

- Эмнэлэгт хэвтүүлэн эмчилнэ.
- Эмчилгээний зорилго шинж тэмдэгийн эмчилгээ хийх, хүндрэлээс сэргийлэх, шаардлагатай арга хэмжээг эрт авахад оршино.
- Өвчтөнг тусгаарлан эмчлэх үед түүний сэтгэлийн түгшүүрийг арилгах нь чухал.
- Хэвтрийн дэглэм баримтална. Илчлэг сайтай хоол хүнсээр хооллож, халуун бүлээн ус, шингэн зүйл сайн уулгана.
- Амин үзүүлэлт болон SpO₂ –ийг өдөрт дунджаар 3-с дээш удаа үзнэ.
- Хүндэвтэр тохиолдолд хатгаа үүсдэг, өвчтөн өндөр эрсдэлт хүчин зүйлтэй бол хүнд хэлбэрт шилжих магадлал нэн өндөр байдаг.
- Тамхи татахыг зогсооно.
- ЦДШ, ШЕШ, БХШ, ийлдсийн шинжилгээ, коагулограмм, цусны өсгөвөр, CRP, ferritin, D-dimer, LDH, ЗЦБ, дүрс оношлогооны шинжилгээнүүдийг хийнэ.
- Бактерийн халдвар сэжиглэсэн бол (эмнэлзүй, лаборатори, дүрс оношлогооны шинжүүд) цэрний өсгөвөр авч, үүсгэгч нянгийн эсрэг гарааны эмчилгээг эхэлнэ.
- Халууралт, амьсгалын шинж тэмдэг, суурь өвчний шинж тэмдгийг эмчилнэ.
- Вирусийн эсрэг эмүүдээс сонгон эмчилнэ.

**Коронавируст халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдолд
гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэхэд баримтлан ажиллах
халдвар хамгааллын дэглэмийн түр заавар**

ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалын 9-р хавсралт, 2021 оны А/29 дугаар тушаалын 3-р хавсралт, 2021 оны 101 дүгээр тушаалыг үндэслэн боловсруулав
Коронавируст халдварын сэжигтэй батлагдсан тохиолдолд гэрээр тусламж үйлчилгээг үзүүлэхдээ халдвар хамгааллын дараах дэглэмийг мөрдөн ажиллана.

1. Тусламж үйлчилгээ үзүүлэх эмчийг томилохдоо аль болох ковидын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эмчийг сонгох
2. Тусламж үйлчилгээ үзүүлэх хүний тоог аль болох цөөн байлгаж нэг удаагийн оролтоор үзлэг оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэхээр зохион байгуулах
3. Эмч эмнэлгийн ажилтан нэг удаагийн иж бүрэн хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөж явна
4. Тусламж үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэсэн аппарат тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ЭМС-ын 2020 оны А/537 дугаар тушаалын 2-р хавсралтаар баталсан зааврыг баримтлан халдваргүйжүүлнэ
5. Тусламж үйлчилгээ үзүүлэх үедээ өвчтөнд хүрэлцсэн бол гадна талын бээлийг үйлчлүүлэгч хооронд солино
6. Тухайн тусламж үзүүлсэн үйлчлүүлэгчийн мэдээллийг аль болох цахим хэлбэрээр авч цаас хэрэглэхгүй байх.
7. Гар утсаа нэг удаагийн гялгар уутанд хийж амыг нь битүүмжлэн авч явна
8. Тусламж үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчид болон гэр бүлийн гишүүдэд гэртээ халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн баримтлах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгнө
9. Тусламж үйлчилгээ үзүүлэхэд өмссөн хамгаалах хувцас хэрэгслийг эмнэлгийнхээ тусгаарлах өрөөний шар бүсд зааврын дагуу тайлна..
10. Гарын эрүүл ахуйг сахина.
11. Хог хаягдлыг цуглуулах, зөөх, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаалыг мөрдөнө.
12. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашигласан тээврийн хэрэгслийн гар хүрэлцэх хэсгүүдийг арчиж халдваргүйжүүлнэ.